



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/563

Хэрлэн сум

Сургалтад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, 2022 оны арваннаймдугаар хуралдааны 12 дугаар сарын 05-ны өдрийн 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Эрүүл мэнд, боловсролын салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн салбарын нийгмийн үзүүлэлтийг сайжруулах зорилгоор эмч эмнэлгийн ажилчдыг чадавхижуулах цогц сургалтыг зохион байгуулахад 14,360,000 (арван дөрвөн сая гурван зуун жаран мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Эмч, эмнэлгийн ажилчдыг чадавхижуулах сургалтын зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Үйл ажиллагааг чанартай дагуу зохион байгуулж, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (Л.Мэндбаяр)-д даалгасугай.

4. Дээрхи зардалд шаардагдах хөрөнгийг Эрүүл мэнд, Боловсролын салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын, 2023  
оны 11 дугаар сарын 06-ны  
дугаар захирамжийн хавсралт

**СУРГАЛТАД ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ.**

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг
1	Бал зардал	100 хүн	2500	250000
2	Дэвтэр зардал	100 хүн	10500	1050000
3	Хавтас	100 хүн	3500	250000
4	Гарын авлага 1	100 хүн*6	2500	1500000
5	Гарын авлага 2	100хүн	3200	320000
5	Бичгийн цаас	3 боодол	20000	60000
4	Сургалтын хэрэглэгдэхүүн /ватум цаас, палмастор, скоч, маркер г.м/	100хүн	15000	1500000
5	Асуумж	100хүн*2	200	40000
3	Их эмч нарт хичээх заах багш нарын цагийн хөлс	5 багш	5 хүн*1 цаг*135000	5670000
4	Сувилахуйн багш нарын цагийн хөлс	4 багш	4 хүн*1 цаг*62500	2000000
5	Багш нарын буудал	4 хоног*8 хүн	30000*8 хүн	960000
6	Замын зардал	Ирэх, буцах зардал-2 талдаа	3 машин-200000	600000
7	Баннер, сургалтын хэрэглэгдэхүүн	2 ш	160000	160000
8	<b>Нийт дүн</b>			<b>14360000 төг</b>